



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар A/21

Улаанбаатар хот

### “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/647 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.5, 4.1.8, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, хоёр орны аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Франц улсаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-ийн талбайд зохион байгуулсугай.

2. “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах зардал 17,000,000 (арван долоон сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 06 сарын 06 өдрийн  
.....*А.М. Ганзориг*..... тушаалын хавсралт



**“ФРАНЦЫН СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Талбайн тохижилтын зардал /тайз, хөгжим, лед, карказ, техник/	6	10,000,000	10,000,000
2	Маркетинг, сурталчилгааны зардал	1	1,000,000	1,000,000
3	Асар түрээсийн төлбөр /4*4 хэмжээтэй/	40 ш/1 өдөр	150,000	6,000,000
Нийт дүн				17,000,000